



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/235

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан 97/56 дугаар тушаалын 4.1.2.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. АШУҮИС-ийн “Сургалтын бодлого зохицуулалтын газар”-тай хамтран зохион байгуулах “Анагаах ухааны боловсрол судлал” сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын  
19 өдрийн тушаалын нэгдүгээр хавсралт

Д  
1235



## “АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛ”

### СУРГАЛТЫН УДИРДАМЖ

#### **Үндэслэл:**

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтыг 16 сургалт эрхлэгч байгуулагад зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Мэргэжлийн чиглэл, индекс батлах тухай” А/184 дүгээр тушаалаар үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын мэргэшлийн чиглэлийг шинэчлэн баталсан. Иймд дээрх тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс сургалт эрхлэгч байгууллагын сургалтын арга зүйч нарыг “Анагаах ухааны боловсрол судлал” сургалтад хамруулж сурган заах арга зүйн ур чадварт суралцуулах, мэргэжил арга зүйгээр хангах шаардлагатай байна.

#### **Зорилго:**

Сургалт зохион байгуулах арга зүй, хөтөлбөрийн үнэлгээ хийх ур чадварт суралцах

#### **Сургалт зохион байгуулах байгууллага:**

- Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургууль

#### **Сургалт зохион байгуулагдах хугацаа, байршил:**

- 2017 оны 12 сарын 25-2018 оны 1 сарын 25-ны өдрүүд
- ЭМХТ-ийн хурлын танхим

**Агуулгын багтаамж:** 2 багц цаг

#### **Эзэмших мэдлэг:**

Сургалтын хөтөлбөрийн зорилтоо биелүүлэхийн тулд сургалтын төлөвлөгөөг хэрхэн зөв зүйтэй боловсруулах, сурган заах арга, лекцийн арга барил, сургалтын үнэлгээг хэрхэн хийх зэрэг мэдлэгтэй болно.

**Эзэмших чадвар:**

Сургалтын арга зүйч нарт шаардагдах хөтөлбөрийн үнэлгээний арга зүй, сургалтын зорилт, төлөвлөгөө боловсруулах арга, асуудалд дүн шинжилгээ хийх арга, үнэлгээ хийх чадварыг эзэмшинэ.

**Эзэмших хандлага:**

Сургалтын арга зүйч нар төгсөлтийн дараах сургалтанд суралцагч нарт чин сэтгэлээсээ хандаж, сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэж боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаагаар дамжуулан Монгол улсын эрүүл мэндийн тусламж үйлчигээг дээшлүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах хандлагыг төлөвшүүлнэ.

**Сургалтын арга зүй:**

- Лекц (PLS – plenary session буюу нэгдсэн хэлэлцүүлэг)
- Багаар ажиллах, багийн ажлын үр дүнг тайлагнах (SGD – small group discussion буюу багийн хэлэлцүүлэг)

**“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛ”  
сургалтын хөтөлбөр**

**2 багц цаг**

д/д	Сэдэв	Цаг	Хичээлийн хэлбэр	Удирдах багш
<b>I өдөр</b>				
1	Анагаах ухааны боловсрол судлалын өнөөгийн чиг хандлага	1	лекц	Профессор Н.Сүмбэрзул, MD, PhD, АШУУИС – ийн дэд захирал
2	Сургалтын тухай ойлголт, насанд хүрэгчдийн сургалт, түүний онцлог	1	лекц	С.Оюунцэцэг, PhD, АШУУИС – ийн СБЗГ, ТӨСА – ны дарга
3	Жижиг бүлгийн хичээл: Ice breaking	4	Жижиг бүлгийн сургалт	С.Оюунцэцэг, PhD, АШУУИС – ийн СБЗГ, ТӨСА – ны дарга Дэд профессор Б.Солонго, MD, PhD, АШУУИС – ийн АУС, УСПБ – ийн ахлагч
<b>II өдөр</b>				
1	Цөм хөтөлбөр, багц цагийн тухай ойлголт	2	лекц	Профессор С.Наранчимэг, АШУУИС, БАС, Харилцааны ур чадварын тэнхимийн эрхлэгч
2	Бүлгийн ажиллагаа: Хөтөлбөрийн зорилго, зорилт тодорхойлох	4	Жижиг бүлгийн сургалт	Профессор С.Наранчимэг, АШУУИС, БАС, Харилцааны ур чадварын тэнхимийн эрхлэгч О.Болормаа, MD, PhD, АШУУИС – ийн СБЗГ, ТӨСА – ны арга зүйч
<b>III өдөр</b>				

1	Хичээл хөтлөн явуулах арга зүй: лекц, on job, off job	2	лекц	Профессор С.Мөнхбаярлах, MD, PhD, АШУУИС, АУС – ийн захирал Дэд профессор Б.Солонго, MD, PhD, АШУУИС – ийн АУС, ДАТ – I, УСПБ – ийн ахлагч
2	Бүлгийн ажиллагаа: Сургалтын стратеги сонгох	4	Жижиг бүлгийн сургалт	Дэд профессор Б.Солонго, MD, PhD, АШУУИС – ийн АУС, ДАТ – I, УСПБ – ийн ахлагч М.Энхтөгөлдөр, PhD, АШУУИС, СБЗГ, Багшийн хөгжлийн төвийн арга зүйч
<b>IV өдөр</b>				
1	Эмнэлзүйн заах арга зүй	2	лекц	Дэд профессор Б.Солонго, MD, PhD, АШУУИС – ийн АУС, ДАТ – I, УСПБ – ийн ахлагч
2	Бүлгийн ажиллагаа: Сургалтын стратеги сонгох	4	Жижиг бүлгийн сургалт	Дэд профессор Б.Солонго, MD, PhD, АШУУИС – ийн АУС, ДАТ – I, УСПБ – ийн ахлагч Д.Энхтуяа, АШУУИС, СБЗГ, ЭМСА – ны арга зүйч
<b>V өдөр</b>				
1	Үнэлгээний хөгжил	2	лекц	Дэд профессор Б.Оюунгоо, MD, PhD, АШУУИС, СБЗГ – ын дарга
2	Бүлгийн ажиллагаа: Үнэлгээний арга зүй сонгох	4	Жижиг бүлгийн сургалт	М.Өсөхбаяр, MD, АШУУИС, СБЗГ, ТӨСА – ны арга зүйч Б.Баярбат, АШУУИС, СБЗГ, ТӨСА – ны арга зүйч
<b>VI өдөр</b>				
1	Багшийн үнэ цэнэ	1	лекц	С.Оюунцэцэг, PhD, АШУУИС – ийн СБЗГ, ТӨСА – ны дарга
	Цахим сургалтын хэрэглээ	1	лекц	Б.Балжинням, АШУУИС, СБЗГ, Зайн сургалтын төвийн дарга
2	Бүлгийн ажиллагаа: Цахим хичээл боловсруулах арга зүй	4	Жижиг бүлгийн сургалт	Б.Балжинням, АШУУИС, СБЗГ, Зайн сургалтын төвийн дарга Т.Сумъяасүрэн, АШУУИС, СБЗГ, Багшийн хөгжлийн төвийн арга зүйч

### **Сургалтын үр дүн:**

Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд сургалт эрхлэгч байгууллагатаа хэрэгжүүлж буй хөтөлбөрт үнэлгээ хийх, шинээр хөтөлбөр боловсруулах мэдлэг ур чадвартай болсноор Сургалт эрхлэгч байгууллагын сургалтын чанар сайжирна.

**“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛ”  
СУРГАЛТАНД СУРАЛЦАХ МЭРГЭЖИЛТНИЙ ТОО**

№	Байгууллага	Албан тушаал	Оролцогчдын тоо
1.	Эрүүл мэндийн хөгжлийн төв	ЭМАХА-ны мэргэжилтэн	6
2.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Сургалтын арга зүйч	2
3.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Сургалтын арга зүйч	1
4.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Сургалтын арга зүйч	2
5.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Сургалтын арга зүйч	2
6.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
7.	Хавдар судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
8.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
9.	Арьсны өвчин судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
10.	Эмгэг судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
11.	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
12.	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
13.	“Ачтан” эмнэлэг	Сургалтын арга зүйч	1
14.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
15.	Геронтологийн үндэсний төв	Сургалтын арга зүйч	1
16.	Нийслэлийн “Өргөө” амаржих газар	Сургалтын арга зүйч	1
17.	<b>НИЙТ</b>		<b>24</b>

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын  
19 өдрийн тушаалын хоёдугаар хавсралт  
1235



“АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛ” СУРГАЛТЫН ТӨСӨВ

	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Сургалтын төлбөр	24 хүн 2 кр	63,000	3.024.000
2	Сургалтын цайны зардал	6 өдөр 24 хүн	2000	288.000
3	Бичиг хэргийн зардал	24 хүн	10.000	240,000
	<b>НИЙТ</b>			<b>3.552.000</b>